

ANNUAL REPORT | 2019



"АРИЛЖААНЫ ТӨЛБӨР
ТООЦОО" ХХК

WWW.MSCC.MN

MISSION
BUSINESS
Strategy
fairness
growth
CCP
OBJECTIVE
Clearing member
operation
INTERNATIONAL
STANDARDS
Sustainable
settlement
Delivery vs Payment
BROKERS
offsetting transactions
Bond
Regulated institutions
DERIVATIVES
PFMI
corporate bond
DCM
PRINCIPLES
CAPITAL
clearing
MARKET
Securities

ИТГЭЛТЭЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ

FOR A SECURE FUTURE

Experience
Risk management
partners
knowledge
CERTIFIED
underwriters
margin
History
VALUES
Licenses
excellence
Technology
Stakeholders
Government bond
shares
VISION
Goal
Compliance
LAW
IOSCO
transparency
promptness
Openness
Collateral deposits
options
Netting
Shareholder
Clients
dealers
Regulation
dividends
GCM
Stock Market
Corporate bond

АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга

Компанийн бүтэц зохион байгуулалт

Төлөөлөн удирдах зөвлөл

Түүхэн товчоон

Компанийн онцлох үйл явдлууд

Хөрөнгийн зах зээл - Клирингийн шинэ үйлчилгээ

2019 оны зорилт, хэрэгжилт

БИЗНЕСИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэт цаасны арилжааны тооцоо, төлбөрийн үйл ажиллагаа

Эрсдэлийн удирдлага

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо

Статистик судалгаа

Комплаенсийн удирдлагын тогтолцоо

Мөнгө угаах болон Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Санхүүгийн тайлангууд

01

02

03

TABLE OF CONTENTS

Message from CEO

COMPANY PROFILE

Brief Introduction

Organizational structure of the company

Board of directors

Organization history bureau

Company highlights

Stock market - New clearing service

2019 objectives and implementations

BUSINESS ACTIVITIES

Securities clearing and settlement operations

Risk Management

Securities primary markets trade settlement /T+0/

Securities secondary markets trade settlement /T+1/

Statistic analysis

Compliance management system

National strategy for anti-money laundering and countering financing of terrorism

FINANCIAL STATEMENT

Audit report

Financial statements



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм таны амрыг эрэхийн ялдамд компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлтийг энэхүү тайлангаар дамжуулан танилцуулж байгаадаа баяртай байна.

Өнгөрсөн 2019 он манай байгууллагын хувьд ололт амжилтаар дүүрэн жил болж өнгөрлөө. Бид үнэт цаасны клирингийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн шуурхай, эрсдэлгүй, найдвартай гүйцэтгэж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжихийг эрхэм зорилгоо болгон хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх зорилтын хүрээнд үнэт цаасны арилжааны дараа төлбөр тооцооны DvP/T+2 горимд шилжих бэлтгэл ажлуудын хүрээнд мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтран “Үнэт цаасны клирингийн журам”-ын төслийг боловсруулан Сангийн сайдын тушаалаар батлагдсан DvP-ийн ажлын хэсгийн түвшинд хэлэлцэн, ҮЦК-иуд болон СЗХ-ны саналыг тусгаж, ТУЗ-өөр батлуулахад бэлэн болгосон.

Мөн төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах үүднээс клирингийн гишүүн, маржин, дефолт гэсэн ойлголт, үг хэллэг, үйл ажиллагааг холбогдох байгууллагууд журамдаа тусгах, оролцогчдод танилцуулах ажлыг хийсэн.

Бид төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, гадаад дотоодын харилцагч иргэд байгууллагын нийт 42.4 тэрбум төгрөгийн анхдагч зах зээлийн арилжаа, 91 тэрбум төгрөгийн хувьцааны, 10 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа явагдсан бөгөөд үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог амжилттай хийж гүйцэтгэв.

Компанийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайлангаар санхүүгийн аливаа “зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдлаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр 2019 онд 991.6 сая төгрөг-ийн нийт орлоготой, 536.0 сая төгрөгийн нийт зардалтай ажиллаж орлогын төлөвлөгөө 97.2 хувийн, зардлын төлөвлөгөө 94.5 хувийн биелэлттэй гарсан байна.

Цаашид хөрөнгийн захын төлбөр тооцоог олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, тооцооны гишүүн элсүүлэх, дараа төлбөрт тогтолцоонд шилжих, эрсдэлийг бүрэн удирдах системийн шинэчлэх ажлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь компани дангаараа гүйцэтгэх боломжгүй бөгөөд мэдсэн, судалснаа бусдадаа танилцуулан асуудлыг хамтран хэлэлцэж, шийдвэр гаргаж явах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дээрх амжилтад хүрэхийн төлөө нэг зорилго төлөвлөгөөтэй хамтран оролцох баг хамт олон, төрийн болон мэргэжлийн байгууллагууд, нийт харилцагчдадаа чин сэтгэлийн талархал илэрхийлж ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Арилжааны төлбөр тооцоо ХХК-ийн гүйцэтгэх захирал,
О.ЭРДЭНЭГЭРЭЛ

MESSAGE FROM CEO

We are pleased to be introducing the company's business plan execution, targets, key economic indicators of 2019 through this report.

Past year has been full of accomplishments and success. We made it our vision to support sustainable growth of the stock market, having clearing service aligned with international standards with fast, secure and reliable services. Under the scope of our goal to introduce new products and services suiting customers' needs, we prepare to shift into DvP2/T+2 procedure by developing "Securities Clearing Rule" in cooperation with associated organizations, which has been discussed in working group on DvP, received input from stock trading companies and Financial Regulatory Commission and is now ready for approval from the board.

In efforts to lower transaction risks, we encouraged stakeholders to include concepts and definitions for terms such as clearing member, margin, default etc.

We have cooperated with government and specialized agencies, providing transaction service successfully for a total of 42.4 billion MNT of primary market transactions, 91 billion MNT of stock trading and 10 billion MNT of government securities transaction.

Report on audit inspection conducted by the National Audit Organization on our company's financial activities for 2019 showed no violations.

According to the audited financial statements, earnings in 2019 totaled 991.6 million MNT with earnings plan fulfillment rate of 97.2 percent while expenses totaled 536.0 million MNT with expense fulfillment rate of 94.5 percent.

As the company is unable to develop stock market transaction systems brought into line with international standards, acquire clearing members, move post trade system, revise risk management system on its own, there is an inevitable necessity to address and solve these issues by sharing knowledge and findings with other agencies.

We express our sincere gratitude and best wishes to our clients, employees, government and specialized agencies who have united under one vision to accomplish the above.

CEO of Mongolian Securites Clearing & Settlement Co., LTD,

O.ERDENEGEREL

I. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

COMPANY PROFILE

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

BRIEF INTRODUCTION

“Арилжааны төлбөр тооцоо” ХХК нь 2016 оны 04-р сард Үнэт цаасны арилжааны дүнд үүссэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх, арилжаанд оролцогчдын үнэт цаас болон мөнгөн төлбөр тооцоо гүйцэтгэх чиг үүрэгтэйгээр зохион байгуулагдсан. Тус компани нь Монголын хөрөнгийн бирж дээр хийгдэж байгаа үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог T+0 өдөр, DvP1 зарчимд, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог T+1 өдөр, DvP2 зарчимд тулгуурлан гүйцэтгэж байна. Мөн Засгийн газрын үнэт цаасны үндсэн ба хүүгийн төлбөрийг харилцагчидтай хийх төлбөрийн тооцоог хариуцан ажиллаж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Үнэт цаасны арилжааны тооцоо, төлбөрийн үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу зохистой гүйцэтгэж, хөрөнгийн захын хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжинэ

АЛСЫН ХАРАА

IOSCO-ийн стандартыг хангасан CCP (Central Counterparty) клирингийн байгууллага болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Түүх, мэдлэг, туршлага
- Мэргэшсэн баг хамт олон
- Бизнесийн хамтрагч, харилцагч
- Тооцооны болон төлбөрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Хууль дүрэм, олон улсын стандартыг чанд мөрдөх
- Шударга, шуурхай, ил тод, нээлттэй байх
- Зөв үзэл, бүтээлч сэтгэлгээг дэмжин хөгжүүлэх

УРИА

- Итгэлтэй ирээдүйн төлөө

“Mongolian Securities Clearing & Settlement Co., LTD” was established in April 2016 with functions of, to determine and execute the settlement payments made as a result of participants’ securities trading. The company is performing securities settlement on the tradings of Mongolian Stock Exchange, primary markets trade settlement on T+0 with DvP1 principle, secondary markets trade settlement on T+1 in DvP2 principle. Also, we are in charge of conducting settlement principals and interest payments on government securities with customers.

MISSION

Promote securities settlement and clearing operations in accordance with international standards and support the sustainable growth of the stock market.

VISION

Become a CCP (Central Counterparty) clearing organization which meets the IOSCO standards.

VALUES

- History, knowledge and experience
- Specialized colleagues
- Business partners and stakeholders
- Licenses for clearing and settlement operations


PRINCIPLES

- Strict compliance the law, regulation, and international standards
- Fair, promptness, transparency, and openness
- Promoting right and creative thinking

SLOGAN

- For the trustworthy future

2. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ORGANIZATIONAL STRUCTURE OF THE COMPANY



"Арилжааны төлбөр тооцоо" ХХК нь 100% төрийн өмчтэй, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч нь Сангийн яам (СЯ) бөгөөд Сангийн сайдын тушаалаар томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлтэй.

Mongolian Securities Settlement & Clearing Co., LTD is a fully state-owned, and the State Property Representative is a Ministry of Finance and it has Board of Directors appointed by the Minister of Finance's order.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ BOARD OF DIRECTORS

ТҮЗ-ийн дарга:

Б.СҮХ-ОЧИР (СЯ-ны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга)

ТҮЗ-ийн хараат гишүүд:

Ч.ЧИМИДСҮРЭН (СЯ-ны НЭТЛАН БОДОХ бүртгэлийн бодлогын газрын дарга)

Б.ЛХАГВА-ОЧИР (СЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтсийн дарга)

В.РЭНЦЭНХАНД (СЯ-ны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн дарга)

Д.БАЛЖИННЯМ (ЗГ-ын хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлага, зохицуулалтын газрын АХЛАХ РЕФЕРЭНТ)

Э.ДУЛАМСҮРЭН (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн)

ТҮЗ-ийн хараат бус гишүүд:

Ж.ЦОГТСАНАА (МОНГОЛ банкны төслийн зөвлөх)

Б.ЭНХТУЯА (ШУТИС-ийн тэргүүлэх профессор, салбарын эрхлэгч)

Ц.БАТСУГАР (IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал)

ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга:

Э.ХОРОЛСҮРЭН ("Арилжааны төлбөр тооцоо" ХХК-ийн хуулийн зөвлөх)

Chairman of the Board:

B.SUKH-OCHIR (HEAD OF DEBT MANAGEMENT DIVISION, FINANCIAL POLICY DEPARTMENT, MINISTRY OF FINANCE)

Board members:

CH.CHIMIDSUREN (HEAD OF ACCOUNTING POLICY DEPARTMENT, MINISTRY OF FINANCE)

B.LKHAGVA-OCHIR (HEAD OF FINANCIAL INFORMATION TECHNOLOGY DIVISION, PUBLIC ADMINISTRATION DEPARTMENT, MINISTRY OF FINANCE)

V.RENTSENKHAND (HEAD OF THE SETTLEMENT DEPARTMENT OF THE TREASURY DEPARTMENT OF THE MINISTRY OF FINANCE)

D.BALJINNYAM (SENIOR OFFICER, STRATEGIC MANAGEMENT AND COORDINATION DEPARTMENT, CABINET SECRETARIAT)

E.DULAMSUREN (SPECIALIST OF STATE PROPERTY POLICY AND REGULATION DEPARTMENT)

Independent board members:

J.TSOGTSANAA (PROJECT CONSULTANT, BANK OF MONGOLIA)

B.ENKHTUYA (LEADING PROFESSOR, HEAD OF BRANCH, MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY)

TS.BATSUGAR (EXECUTIVE DIRECTOR OF IRIM RESEARCH INSTITUTE)

Secretary of the Board:

E.KHOROLSUREN (LEGAL ADVISOR OF MONGOLIANS SECURITIES CLEARING SETTLEMENT Co.,LTD)

3. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧООН ORGANIZATION HISTORY BUREAU



MONGOLIAN SECURITIES
CLEARING & SETTLEMENT CO.,LTD

2016 онд “ҮЦТТХТ” ХХК-ийг өөрчлөн зохион байгуулж **“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО” ХХК** байгуулагдав. In 2016, “SCHSD” LLC was reorganized and **Mongolian Securities Clearing & Settlement Co., LTD** was established.



Asia-Pacific CSD Group

2018 онд -ACG олон улсын байгууллагын гишүүнээр элсэв. -Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 4.0 тэрбум төгрөг болгов. -RTGS системийн II хувилбарт шилжив. In 2018, -Became a member of ACG the International organization. -The company's share capital increased to MNT 4.0 billion. -Moved to RTGS system version II.

ACH+ DvP/T+2

2019 онд Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны шинэчлэл хийгдэв. (ACH+) Төлбөр тооцооны T+2 горимоор DvP зарчмыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллав. In 2019, low volume of interbank transactions settlement were reformed. (ACH+) A workshop group formed to implement the DvP principles based on the T+2 settlement regime.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

2017 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос (СЗХ) тусгай зөвшөөрөл олгов. In 2017, issued a license by Financial Regulatory Commission (FRC).



2018 онд Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны шинэчлэл хийгдэв RTGS.V2 In 2018, a large amount of interbank transactions settlement were reformed RTGS.V2

4. КОМПАНИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД COMPANY HIGHLIGHTS

2016 ОН

- Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх үүрэг бүхий бие даасан байгууллага болж "Арилжааны төлбөр тооцоо" ХХК нэртэйгээр байгуулагдлаа.
- "Нэг шийдэл-Нэгдсэн зорилго" анхдугаар хэлэлцүүлгийн хүрээнд Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудтай "Хамтын ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурлаа

2017 ОН

- Үнэт цаасны арилжааны тооцооны болон төлбөрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг СЗХ-оос авлаа.
- Төлбөр тооцооны системийн шинэчлэл хийх зорилго бүхий "DvP-ийн ажлын хэсэг" байгуулагдав.

2018 ОН

- Банк хоорондын их дүнтэй гүйлгээний RTGS системийн II хувилбарт шилжив.
- Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 4.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэв.
- СЗХ-оор ахлуулсан "DvP нэвтрүүлэх ажлын хэсэг" байгуулагдсан.
- ACG (Asia Pacific Central Securities Depository Group) олон улсын байгууллагын гишүүнээр элсэв.
- Эрсдлийн удирдлагын багц журмын төслийг боловсруулан СЗХ-оор батламжлуулахаар хүргүүлэв
- Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны хамтрагч гишүүнээр элсэв.
- Харилцагч байгууллагуудад бодит цагийн горимд мэдээлэл хүргэх зорилго бүхий API шийдлийг нэвтрүүлэв.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлав.

2019 ОН

- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны шинэчлэл хийгдэв (ACH+)
- Сангийн ямаар ахлуулсан "DvP ажлын хэсэг" байгуулагдаж АТТ,ҮЦТХ-н журмын төслүүд боловсруулагдан 2019 оны эцэст нэгдсэн шийдэлд хүрсэн.

2016

- Established as Mongolian Securities Clearing & Settlement Co.,LTD as an independent organization responsible for performing a securities settlement.
- A Memorandum of Understanding was signed with professional securities market participants within the framework of the first "One Solution-Common Goal" discussion

2017

- Obtained a license from the FRC for securities clearing and settlement activities.
- A "DvP workshop group" was established to reform the settlement system.

2018

- Moved to version II of the RTGS system of a large volume interbank transactions.
- The company's share capital was increased to 4.0 billion MNT.
- A "DvP implementation Workshop group" chaired by FRC was established. Joined as membership of ACG (Asia Pacific Central Securities Depository Group) International Organization.
- A Set Risk Management Procedure was draughted and submitted to the FRC for approval.
- Became an associate member of the Mongolian Association Securities of Dealers.
- Introduced API solution to provide real-time mode information delivery to the customers.
- Approved the accounting policy document.

2019

- Low volume of interbank transactions settlement was reformed (ACH+)
- A "DvP workshop group" chaired by the Ministry of Finance (MOF) was established, draught regulations for the MSCC and MCSD were developed and reached a unified solution at the end of 2019.

5. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ - КЛИРИНГИЙН ШИНЭ ҮЙЛЧИЛГЭЭ STOCK MARKET - NEW CLEARING SERVICE

“Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т санхүүгийн үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэхээр заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Сангийн яам (СЯ)-наас хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран клирингийн шинэ үйлчилгээ буюу төлбөр тооцооны T+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт аргачлалыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс нэвтрүүлэхээр бэлтгэл ажлууд хангагдаж байна.


Хөрөнгийн зах зээлд клирингийн шинэ үйлчилгээг нэвтрүүлснээр хөрөнгө оруулагч гадаад, дотоодын иргэн, ААН-үүд үнэт цаасны арилжаанд оролцоходоо урьдчилгаа төлбөр байршуулах замаар захиалгаа баталгаажуулан, үлдэгдэл төлбөрөө T+2 хугацаанд байршуулах боломжтой болох юм. Ингэснээр үнэт цаасны арилжаанд оролцогчид хэлцэл хийгдээгүй байхад их хэмжээний мөнгийг үнэт цаас худалдан авахад зориулан түгжих шаардлагагүй болно. Мөн үүнтэй зэрэгцэн хөрөнгийн зах зээл дэх мөнгөн урсгалыг аль болох хялбар болгох зорилго тавьлаа.

Төлбөрийн эрсдэл (дефолт)-ийг олон улсын стандартын дагуу санхүүгийн болон мэргэжлийн өндөр чадавх бүхий клирингийн гишүүн элсүүлэх, төлбөрийн тодорхой хувиар тооцон урьдчилгаа буюу маржин барьцаа авах, эрсдэл (дефолт)

According to the “National Program for the Development of the Financial Market of Mongolia until 2025”, to develop financial services in accordance with international standards, the Financial Regulatory Commission (FRC) and the Ministry of Finance (MOF), in cooperation with professional stock market organizations, are preparing to introduce a new clearing service, the T + 2 settlement regime and Delivery versus Payment system, starting March 31, 2020.

With the introduction of the new clearing service in the stock market, foreign and domestic investors and companies will be able to confirm their orders by placing an advance payment in T+2. This eliminates the need for securities traders to lock a large amount of money for the purchase of securities in the absence of a transaction. At the same time, we aim to make cash flow in the stock market as easy as possible.

Payment risk (default) will be managed through instruments in accordance with international standards the recruitment of financially and professionally qualified clearing members, obtaining an advance or margin collateral at a certain rate of payment, and establishing a mutual fund to use in case of risk (default).



үүссэн үед ашиглах дундын сан байгуулах зэрэг арга хэрэгслээр дамжуулан удирдах бөгөөд одоогоор “Үнэт цаасны клирингийн журам” батлагдан энэхүү журмын зохицуулалтын хүрээнд клирингийн гишүүн элсүүлэх, гишүүнчлэлийн гэрээ байгуулах, систем программ хангамжийг хөгжүүлэх, турших ажлууд хийгдэж байна.

Currently, the “Securities Clearing Rule” has been approved and within the framework of this rule, clearing member recruitment, membership agreement, system software development, and testing are underway.

6. 2019 ОНЫ ЗОРИЛТ, ХЭРЭГЖИЛТ

2019 OBJECTIVES AND IMPLEMENTATIONS

2019 онд төлбөр тооцооны системийн шинэчлэх ажлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг гол зорилтоо болгон ажилласан.

1. Үнэт цаасны тооцоо, төлбөрийн үйл ажиллагааны зохицуулалт, технологи, үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн үр ашигтай зохион байгуулна.

2. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тооцоо, төлбөрийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлнэ.

3. Эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоог нэвтрүүлж, төлбөр тооцооны хэвийн тогтвортой үйл ажиллагаа, системийн болон мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангана.

4. Үнэт цаасны тооцоо, төлбөрийн үйл ажиллагаанд хамтран оролцогч мэргэжлийн байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

5. Мэргэжлийн өндөр үр чадвар бүхий тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөц бүрдүүлэх, тэдний мэдлэг, мэргэжлийг тогтмол дээшлүүлэх, нийгмийн асуудлыг сайжруулахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

6. Компанийн хөрөнгийг өсгөн нэмэгдүүлнэ.

Төлбөр тооцооны системийн шинэчлэлийг компани дангаараа гүйцэтгэх боломжгүй бөгөөд мэдсэн, судалснаа бусдадаа танилцуулан асуудлыг хамтран хэлэлцэж, шийдвэр гаргаж байсан маань хугацаа алдсан ч үр дүнтэй байлаа. Тухайлбал:

In 2019, our main goal was to implement the settlement system reform in our operations.

1. The securities settlement, payment operational coordination, technology, and operations shall be effectively organized in accordance with international standards.

2. Introduce new settlement processes and services that meet customer demands.

3. Introduce an appropriate risk management system and fully ensure the normal and stable operation of settlements, system and information security.

4. Develop mutually beneficial cooperation with specialized organizations, who involves securities settlement activities.

5. Provide support to build a professional highly skilled and sustainable workforce, continuously improve their knowledge and skills, and improve social issues.

6. Increase the company's assets.

It is impossible to reform the whole process of the settlement system for a company on its own. But it was efficient to share our learnings and research with other entities, even though it took some time to make discussions and decisions. In particular:

-Үнэт цаасны клирингийн журамьг боловсруулахдаа EBRD-ын зөвлөмжид тулгуурласан бөгөөд энэхүү журам нь ҮЦТХТ-ийн боловсруулсан "Төлбөрийн үйл ажиллагааны журам", МХБ-ийн "Гишүүний журам"-тай уялдсан.

-Мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны зураглалыг шинэчлэн гаргасан. Үүнтэй холбоотойгоор үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагааг ҮЦТХТ гүйцэтгэх, барьцаа, төлбөрийн баталгаа зэрэг эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг АТТ гүйцэтгэх, ҮЦК-иуд тооцооны гишүүнчлэлийн хүрээнд төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцох, төлбөр гүйцэтгэх банкны үүрэг өөрчлөгдөх гэх мэт олон асуудлуудыг хамтран шийдвэрлэсэн.

-Компани бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр нийт 51 ажил төлөвлөсөн бөгөөд 36 ажил 100%, 12 ажил 90%, 2 ажил 80%, 1 ажил 50%-ийн гүйцэтгэлтэй биелсэн байна. Төлбөр тооцооны системийн шинэчлэлтэй холбоотой ажилын гүйцэтгэл 80-90%-ийн гүйцэтгэлтэй, нөөц төвтэй холбоотой ажлын гүйцэтгэл 50-80%-ийн гүйцэтгэлтэй байлаа.

-Зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан компанийн орлогын төлөвлөгөө биелээгүй хэдий ч компанийн удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн сахилга батыг зөв удирдан төлөвлөсөн хэмжээнд ашигтай ажиллаж зорилтот түвшин 100%-иар биелэж 407.0 сая төгрөгний ашигтай ажиллаа.

-The Securities Clearing Rule draught based on the EBRD's recommendations and is in line with the "Settlement Operation Procedure" developed by the MCSD and the MSE's "Membership Procedures".

-Revised the activity map of specialized organizations. In this regard, a number of issues have been resolved, such as the execution of securities settlements by the MCSD, the performance of risk management activities such as collateral and settlement guarantees by MSCC, participation in settlement activities within the framework of Securities companies Clearing membership and the change in the role of Settlement banks.

-The company planned to implement its business plan for a total of 51 projects, of which 36 projects were 100% completed, 12 projects were completed 90%, 2 projects were completed 80%, and 1 project was completed 50%. The work related to the settlement system reform was 80-90% complete, and the work related to the reserve center was 50-80% complete.

-The company's management, ordonnance, and financial discipline were properly managed, and the targets achieved with 100% and the profit was 407.0 million MNT, even though the company's revenue plan hasn't fulfilled due to the market conditions.

II. БИЗНЕСИЙН ҮНДСЭН ҮЙЛАЖИЛЛАГАА BUSINESS ACTIVITIES


1. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТООЦОО ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

SECURITIES CLEARING AND SETTLEMENT OPERATIONS

Монголын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа, бонд гэсэн 2 төрлийн үнэт цаас арилжаалагдаж байгаа бөгөөд анхдагч болон хоёрдогч зах зээлийн төлбөр тооцоо T+0, T+1 горимуудаар хийгдэж байна.


Two types of securities traded on the Mongolian Stock Market, which are stocks and bonds. Primary and secondary markets settlement are made in T+0 and T+1 modes.

Үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны тооцоо, төлбөрийн үйл ажиллагааны горим



2. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

RISK MANAGEMENT



Урьдчилсан төлбөрт тогтолцооноос дараа төлбөрт тогтолцоонд шилжих үед нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ нь эрсдэлийг хуваалцах үүрэг бүхий Клирингийн гишүүний үйл ажиллагаа юм. Үүнтэй холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох зохицуулалтыг “Үнэт цаасны клирингийн журам”-д тусгасан. Үүнд:

- Тооцооны гишүүний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон
- Тооцооны гишүүнд тавигдах шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон үнэт цаасны арилжаанд оролцогчдод танилцуулах, санал авах ажлуудыг зохион байгуулсан.
- Тооцооны гишүүний үүргийг гүйцэтгэх боломж бүхий оролцогчдыг тодорхойлох зорилгоор холбогдох судалгаануудыг хийсэн.

Төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор маржин, барьцаа хөрөнгө, төлбөрийн баталгааны сангийн ойлголтуудыг тодорхой болгон “Үнэт цаасны клирингийн журам”-д заалт болгон оруулсан.

The foremost step in the transition from a prepaid to the post-trade system is to implement Clearing Member activities responsible for risk-sharing. The following activities have been carried out in this regard and the relevant regulations are reflected in the “Securities Clearing Rule”.

These include:

- Criteria for Clearing members have been defined
- Defined the requirements, rights, duties, and responsibilities of the Clearing member and introduced them to the securities trading participants and organized the polling activities.
- Relevant researches were conducted in order to identify potential participants to act as Clearing members.

In order to reduce and manage settlement risk, the concepts of margin, collateral and settlement guarantee funds have been defined and included in the “Securities Clearing Rule”.

3. ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО /T+0/ SECURITIES PRIMARY MARKETS TRADE SETTLEMENT /T+0/

2019 онд үнэт цаасны анхдагч зах зээлд Засгийн газрын бонд, компанийн бондын арилжаа хийгдээгүй бөгөөд шинээр 4 хувьцаат компанийн IPO хийгдэж 42,4 тэрбум төгрөгийн төлбөр, тооцоог хийж гүйцэтгэлээ. Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд тайлант хугацаанд нийт 47 ҮЦК оролцсон байна.

In 2019, no government bonds or corporate bonds were traded in the primary securities market, and 4 new joint-stock companies launched IPO and settled 42.4 billion MNT. During the reporting period, a total of 47 securities companies participated in primary market trading.

(In million MNT)				
Year	Government Bond	Company Bond	Stock Trade	Total
2016*	224,724.0	-	-	224,724.0
2017	630,204.9	6,000.0	1,338.8	637,543.7
2018	-	-	31,443.2	31,433.2
2019	-	-	42,457.4	42,457.4
Total	854,928.9	6,000.0	75,229.4	936,158.3



*2017 онд Компанийн бондын 6 тэрбум төгрөгний арилжаа МХБ-дээр арилжаалагдсанаас хойш компанийн бонд арилжаалагдаагүй байна.


* 6 billion MNT of corporate bonds were traded last on the MSE in 2017. Since then company bonds have not been traded.

4. ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО /T+1/ SECURITIES SECONDARY MARKETS TRADE SETTLEMENT /T+1/

2019 онд үнэт цаасны хоёрдогч зах зээлд МХБ-ээр нийт 187 удаагийн арилжаа явагдсан бөгөөд үүнээс 251 удаагийн арилжаанд 91,054.6 сая төгрөгийн хувьцааны, 37 удаагийн арилжаанд 10,136.8 сая төгрөгийн ЗГҮЦ-ны, нийт 101,191.3 төгрөгийн хоёрдогч зах зээлийн арилжаа явагдсан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаанд нийт 51 ҮЦК оролцож төлбөр тооцоог T+1 хугацаанд дээрх дүнгээр цэвэршүүлэн төлбөр тооцоог гүйцэтгэлээ.

In 2019, a total of 287 trades were made on MSE, of which 91,054.6 million MNT were traded in 251 trades, 10,136.8 million MNT worth of government securities were traded in 37 trades, and a total of 101,191.3 MNT were traded in the secondary market. A total of 51 Securities companies participated in the secondary market trading and settlement made in T+1 period.

(In million MNT)					
Year	Government Bond	Company Bond	Stock Trade	Total	Cleared amount of settlement
2016*	15,358.1	-	37,247.0	52,605.0	8,958.0
2017	143,285.4	4,295.6	75,110.2	222,691.2	27,737.5
2018	34,486.9	723.7	178,569.0	213,779.7	33,395.7
2019	10,136.8	-	91,054.6	101,191.3	15,472.9
Total	203,267.1	5,019.3	381,980.8	590,267.2	85,564.1




4. СТАТИСТИК СУДАЛГАА

STATISTIC ANALYSIS


Үнэт цаасны арилжаанд оролцогчдын тоог хувиар илэрхийлэвэл

Participants' trade values in securities trading by percentage



Үнэт цаасны арилжаанд оролцогчдын үнийн дүнг хувиар илэрхийлэвэл

Number of trades participated in securities trading by percentage




(In million MNT)

Үзүүлэлт		2017		2018		(in million MNT)	
		Number of trades participated	Trading price amount	Number of trades participated	Trading price amount	Number of trades participated	Trading price amount
Foreign	Entity	2,972	10,595.7	1,955	89,176.7	654	19,369.57
	Citizen	1,902	24,318.6	3,565	6,961.0	1,899	14,440.25
Domestic	Entity	3,123	657,613.2	4,709	99,948.1	9,088	68,769.83
	Citizen	30,072	167,707.4	56,313	49,127.1	47,183	39,640.08

Засгийн газрын үнэт цаасны арилжаа

Government Bond Trade




Компанийн бондын арилжаа

Corporate Bond Trade



Хувьцааны арилжаа

Stock Trade



5. КОМПЛАЕНСИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

COMPLIANCE MANAGEMENT SYSTEM

Комплаенсийн үйл ажиллагааны бодлого, хөтөлбөр болон холбогдох дүрэм, журам заавар аргачлалуудын анхны хувилбарыг боловсруулан батлуулахад бэлэн болоод байна. Эдгээр нь комплаенсийн удирдлагын тогтолцооны бүтэц бүрэлдэхүүн, тэдгээрийн чиг үүргийг тодорхой болгож, компанийн дагаж мөрдвөл зохих комплаенсийн үүргийг тодорхойлох, бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Дээрх ажлын хүрээнд компанийн дотоод дүрэм, ёс зүйн хэм хэмжээ, аливаа үүрэг даалгаврыг зохистой түвшинд хэрэгжүүлэх, “Хамгаалалтын гурван шугамын загвар”-ыг бэхжүүлэхэд дэмжлэг болж, үл нийцлээс үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх комплаенсийн удирдлагын тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан Комплаенсийн сургалт болон бусад зохион байгуулалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцон хамтран ажиллаж байна.

The first version of the Compliance policy, program, and related rules, regulations, and guidelines are draughted and ready for approval. These are important for clarifying the structure and functions of a compliance management system and their functions, and for defining, recording, monitoring, and effectively enforcing the company's compliance obligations.

Within the framework of the above, we are planning to implement the company's internal rules, code of ethics and any tasks at a proper level, to support the strengthening of the “Three Lines of Defense model” and to implement a compliance management system to prevent potential non-compliance risks.

We are actively involved in Compliance training and other management activities organized by the Financial Regulatory Commission.

6. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

NATIONAL STRATEGY FOR ANTI-MONEY LAUNDERING AND COUNTERING FINANCING OF TERRORISM

Тайлант хугацаанд бид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол улсын хууль, олон улсын болон ажиллагаандаа мөрдөж ажиллаж байгаа бөгөөд тэдгээрт нийцүүлэн мөнгө угаахтай тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр, бодлого, журмыг боловсруулан гаргахаар ажиллаж байна.

Бид ийнхүү үйл ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэхдээ хөрөнгийн зах зээлд оролцогч компаниудтай сургалт, судалгааны чиглэлээр мэдээлэл туршлагаа солилцон хамтран ажиллаж “харилцагчийг таньж мэдэх” зорилгоор харилцагчийн мэдээллийг баталгаат эх сурвалж, баримт бичигт тулгуурлан хянаж баталгаажуулсны дагуу үйлчилгээ үзүүлж хамтран ажиллахаар зорьж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 20 саяас дээш үнийн дүн бүхий гүйлгээний талаар сар бүр Монгол банкны Санхүү мэдээллийн албанд дэлгэрэнгүйгээр буюу харилцагч нэг бүрээр гарган тайлан гарган өгч хамтран ажиллаж байна.

During the reporting period, we complied with Mongolian laws on anti-money laundering and countering the financing of terrorism, internationally and in practice, and in accordance with that, we are working to develop internal control programs, policies, and procedures to combat money laundering.

In order to effectively implement this activity, we aim to cooperate with stock market participant companies by exchanging information and experience in the field of training and research and, to provide services based on verified customer information and reliable sources and documents in order to ensure “know your customer”.

Within the framework of the implementation of the Law on Anti-Money Laundering and Countering Financing of terrorism, we are cooperating with the Financial Information Office of the Bank of Mongolia on a monthly basis by issuing detailed reports on transactions of more than 20 million MNT.

III. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

FINANCIAL STATEMENTS

1. АУДИТЫН ТАЙЛАН

AUDIT REPORT



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага төлрүү: 3, Засгийн газрын IV баир
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/2020
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн дэлгэрэнгүй тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид сэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний тайлан дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО

ҮЦК ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТ



Ц.НАРАНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3, Засгийн газрын IV бэлэр
Утас: 26 04-37, Факс: 62 26-32-90
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/2015
Танай _____-ны № _____-т

Audit Certificate

We have conducted financial comprehensive and detailed report audit on the disclosure and financial statement of "Mongolian Securities Clearing & Statement" Co.,Ltd ended as of 31st December, 2019 in accordance with Provision #15.2 of Article #15 and Provision #18.5 of Article #18 of Auditing Law of Mongolia and Paragraph #8.9.8 of Article #8 of Law on Budget of Mongolia.

Non-contradictory opinion

We are hereby making non-contradictory opinion because "Mongolian Securities Clearing & Statement" Co.,Ltd has expressed and submitted its Property Changes Report, Cash-Flow Report, Income Comprehensive Report and Financial Statement as of 31st December, 2019 accurately in accordance with IAS and other relevant laws and regulations.

Grounds for opinion

The National Audit Office has conducted such Audit according to Financial Statement Audit Regulation and Directions approved by The General Auditor of Mongolia in compliance with ISA, other standards and principle acknowledged publically by Audit Authority. For the purpose to obtain the evidence with ground on whether those financial statement is free from wrong expression, it is required to plan and perform the audit.

Through the audit, the biggest calculations, estimations and reports made by management, internal inspection system, software, reporting and accounting policy, which has being followed at the company, the disclosure and amount of transaction report and balance in disclosure and financial statement of "Mongolian Securities Clearing & Statement" Co.,Ltd ended as of 2019.

TO: "MONGOLIAN SECURITIES
CLEARING & SETTLEMENT" CO.,LTD,
CEO, ERDENEGERELO


The audit we conducted has obtained sufficient and appropriate ground basis to make opinion on financial statement and highlights, and we have reflected the suggestions in the audit report based on result of audit.

Responsibilities and obligations


"Mongolian Securities Clearing & Statement" Co.,Ltd is obligated to prepare, report and submit its disclosure and financial statement of reporting period pursuant to IFRS and other relevant standards according to Regulation and Directions approved by Minister of Finance and in accordance with Accounting Law of Mongolia.

The Governmental Organization is obligated to conduct audit according to ISA, standard and principle acknowledged publically by National Audit Office and to issue suggestion and opinion for year-end financial statement.

DIRECTOR OF FINANCIAL
AUDIT DIVISION
LEADING AUDITOR



TS.NARANCHIMEG



2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

FINANCIAL STATEMENTS

Statement of financial position as of 31 December 2019

(by MNTs)

Num	Particulars	December 31, 2018	December 31, 2019
1	ASSETS		
1.1	Current assets		
1.1.1	Cash	5,806,051,621.88	5,294,218,258.24
1.1.2	Trade receivable	5,621,917.81	93,726,849.31
1.1.3	Other receivable		
1.1.4	Other financial asset	19,852.00	
1.1.6	Inventories	336,700.00	348,420.00
1.1.7	Pre-payment	595,630.63	-
1.1.11	Total current assets	<u>5,812,625,722.32</u>	<u>5,388,293,527.55</u>
1.2	Non-current Assets		
1.2.1	PROPERTY, PLANT AND EQUIPMENT	57,778,519.97	91,332,424.73
1.2.2	Intangible assets	11,437,603.20	108,640,605.63
1.2.6	Deferred tax assets	1,914,881.40	2,822,691.31
1.2.8	Other non-current assets		
1.2.10	Total non-current asset	<u>71,131,004.57</u>	<u>202,795,721.67</u>
1.3	TOTAL ASSET	<u>5,883,756,726.89</u>	<u>5,591,089,249.22</u>
2	EQUITY AND LIABILITIES		
2.1	LIABILITIES		
2.1.1	Current liabilities		
2.1.1.1	A debt of participants trading	954,699,704.48	458,054,289.12
2.1.1.3	Current tax payable	58,491,150.48	8,889,588.84
2.1.1.4	Social Insurance Payable	460,000.00	40,000.00
2.1.1.10	Other payables	810.00	69,597.22
2.1.1.13	Total current liabilities	<u>1,013,651,664.96</u>	<u>467,053,475.18</u>

2.1.2	Non-current liabilities		
2.1.2.3	Deferred tax	1,914,881.40	2,822,691.31
2.1.2.6	Total non-current liabilities	<u>1,914,881.40</u>	<u>2,822,691.31</u>
2.2	TOTAL LIABILITIES	<u>1,015,566,546.36</u>	<u>469,876,166.49</u>
2.3	EQUITY		
2.3.1	Share capital - State	4,000,000,020.75	4,000,000,020.75
2.3.6	Gain on property revaluation	9,560,000.00	9,560,000.00
2.3.8	Other components of equity		
2.3.9	Retained earning	858,630,159.78	1,111,653,061.98
2.3.11	TOTAL EQUITY	<u>4,868,190,180.53</u>	<u>5,121,213,082.73</u>
2.3.20	TOTAL EQUITY & LIABILITIES	<u>5,883,756,726.89</u>	<u>5,591,089,249.22</u>

Statement of profit & loss as of 31 December 2019

(by MNTs)

Particulars	December 31,2018	December 31,2019
SALES REVENUE		
Trade commission income	1,818,830,521.28	642,508,173.59
Other income	49,000.00	346,500.00
Total Revenue	<u>1,818,879,521.28</u>	<u>642,854,673.59</u>
Operating expenses		
General and administrative expenses	416,857,794.82	520,699,267.09
Other expenses	19,889,931.93	16,136,862.00
Total operating expenses	<u>436,747,726.75</u>	<u>536,836,129.09</u>
Gross profit	1,382,131,794.53	106,018,544.50
Non-operational Revenue		
Finance income	318,809,599.58	348,810,826.21
Profit Before Tax	898,603,852.56	454,829,370.71
Income tax expense	92,750,762.91	46,188,813.36
PROFIT FOR THE YEAR	<u>805,853,089.65</u>	<u>408,640,557.35</u>



MONGOLIAN SECURITIES CLEARING &
SETTLEMENT CO.,LTD

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Сүхбаатарын талбай-3,
“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн байр, 2 давхар



<https://www.facebook.com/att.ccp>



Info@mscc.mn



https://twitter.com/MSCC_Mongolia



www.mscc.mn



7011-0104, 7011-3672



ANNUAL REPORT | 2019



"АРИЛЖААНЫ ТӨЛБӨР
ТООЦОО" ХХК

WWW.MSCC.MN